**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/66/СТА-ТШЗ***

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ....... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 9
3. Аудитын тайлан ....... 10
3.1. Ерөнхий зүйл ....... 10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....... 10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....... 10
3.4. Материаллаг байдал ....... 11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....... 11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....... 11
3.7. Шилэн дансны мэдээлэл ....... 12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 12
3.9. Аудитын илрүүлэлт ....... 13
Залруулсан алдаа ....... 13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....... 13
Аудитын зөвлөмж ....... 14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....... 15
4. Менежментийн захидал ....... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....... 15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.17 № 58

танай __________ -ны № __________ -т

ХЭРЛЭН СУМЫН 12 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.АЛТАНСУВД ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

011020063

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, заавры дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **77,151,490.50** | **68,890,647.50** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 831,587.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 831,587.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 77,151,490.50 | 68,059,060.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 77,151,490.50 | 68,059,060.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,056,810.00 | 4,373,710.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 71,144,680.50 | 59,842,780.50 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 1,892,570.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,950,000.00 | 1,950,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,391,248,949.71** | **1,425,280,589.45** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,391,248,949.71 | 1,425,280,589.45 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,154,573,949.71 | 1,188,424,089.45 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,159,452,140.17 | 1,200,163,040.17 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -33,563,386.08 | -67,126,772.16 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 45,715,605.50 | 60,709,367.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39,154,680.54 | -39,370,307.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,730,475.02 | 53,792,002.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,486,204.36 | -31,879,257.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,600,000.00 | 13,576,016.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -720,000.00 | -1,440,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 236,675,000.00 | 236,856,500.00 |
| 39301 | Програм хангамж | 440,000.00 | 621,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -440,000.00 | -440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 236,675,000.00 | 236,675,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,468,400,440.21** | **1,494,171,236.95** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **831,587.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 831,587.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 831,587.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 831,587.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 831,587.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,468,400,440.21** | **1,493,339,649.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,468,400,440.21 | 1,493,339,649.95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 335,168,505.40 | 335,168,505.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 335,168,505.40 | 335,168,505.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 635,210,750.18 | 660,149,959.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 635,210,750.18 | 635,210,750.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 24,939,209.74 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 498,021,184.63 | 498,021,184.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,468,400,440.21** | **1,494,171,236.95** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **520,025,329.60** | **625,669,978.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,179,529.60** | **73,854,878.50** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,388,500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,388,500.00 | 00.00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 2,791,029.60 | 73,854,878.50 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 2,791,029.60 | 73,854,878.50 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **32,465,400.00** | **28,212,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 479,380,400.00 | 523,602,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 198,000.00 | 140,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 198,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,267,400.00 | 28,072,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,267,400.00 | 28,072,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **556,040,904.06** | **600,730,768.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **556,040,904.06** | **600,730,768.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 550,957,042.06 | 579,269,031.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,559,400.00 | 396,802,514.00 |
| 210101 | Үндсэн цалин | 283,980,000.00 | 297,205,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 17,271,500.00 | 69,464,914.00 |
| 210104 | Урамшуулал | 30,307,900.00 | 30,132,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,444,600.00 | 49,606,473.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,182,400.00 | 33,732,410.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,315,600.00 | 3,968,566.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,652,600.00 | 3,175,073.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 662,900.00 | 793,493.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,631,100.00 | 7,936,931.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,083,538.00 | 26,244,786.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,761,430.00 | 4,309,021.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,524,133.00 | 12,688,870.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,797,975.00 | 9,246,895.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,897,775.04 | 15,974,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 405,900.00 | 439,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 313,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 210,000.00 | 165,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 599,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 630,000.00 | 261,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,051,875.04 | 13,695,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,847,400.00 | 48,471,850.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 160,000.00 | 424,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 98,487,400.00 | 47,742,650.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200,000.00 | 304,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 825,100.00 | 456,570.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 645,100.00 | 216,570.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 42,539,229.02 | 41,712,738.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,026,000.00 | 1,208,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,013,229.02 | 40,004,738.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,083,862.00 | 21,461,737.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 188,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 188,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,783,862.00 | 21,273,437.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,783,862.00 | 21,273,437.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-36,015,574.46** | **24,939,209.74** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-36,015,574.46** | **24,939,209.74** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **511,845,800.00** | **551,815,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **511,845,800.00** | **551,815,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 479,380,400.00 | 523,602,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 198,000.00 | 140,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 198,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 32,267,400.00 | 28,072,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 32,267,400.00 | 28,072,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **511,845,800.00** | **551,815,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **511,845,800.00** | **551,815,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **506,761,938.00** | **530,353,363.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 331,559,400.00 | 396,802,514.00 |
| 210101 | Үндсэн цалин | 283,980,000.00 | 297,205,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 17,271,500.00 | 69,464,914.00 |
| 210104 | Урамшуулал | 30,307,900.00 | 30,132,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,444,600.00 | 49,606,473.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,182,400.00 | 33,732,410.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,315,600.00 | 3,968,566.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,307,059.00 | 3,175,073.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 662,900.00 | 793,493.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,976,641.00 | 7,936,931.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,083,538.00 | 26,244,786.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,761,430.00 | 4,309,021.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,524,133.00 | 12,688,870.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,797,975.00 | 9,246,895.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,741,900.00 | 3,364,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 441,900.00 | 547,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 313,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 201,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 688,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,400,000.00 | 1,113,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,847,400.00 | 51,816,520.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 160,000.00 | 424,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 98,487,400.00 | 49,635,220.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,200,000.00 | 1,757,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,400,000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 360,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 360,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 825,100.00 | 638,070.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 645,100.00 | 398,070.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,500,000.00 | 1,880,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,380,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,083,862.00** | **21,461,737.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 188,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 188,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,783,862.00 | 21,273,437.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,783,862.00 | 21,273,437.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд-сан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **335,168,505.40** | **498,021,184.63** | **635,210,750.18** | 1,468,400,440.21 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **335,168,505.40** | **498,021,184.63** | **635,210,750.18** | 1,468,400,440.21 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **335,168,505.40** | **498,021,184.63** | **635,210,750.18** | 1,468,400,440.21 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 24,939,209.74 | 24,939,209.74 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **335,168,505.40** | **498,021,184.63** | **660,149,959.92** | 1,493,339,649.95 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 558,917,800.00 | 530,401,663.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 558,917,800.00 | 530,401,663.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 558,729,500.00 | 530,213,363.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 398,054,700.00 | 396,802,514.00 |
| 210101 | Үндсэн цалин | 297,205,500.00 | 297,205,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 70,717,100.00 | 69,464,914.00 |
| 210104 | Урамшуулал | 30,132,100.00 | 30,132,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,756,900.00 | 49,606,473.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,834,700.00 | 33,732,410.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,980,600.00 | 3,968,566.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,184,700.00 | 3,175,073.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 795,900.00 | 793,493.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,961,000.00 | 7,936,931.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,072,800.00 | 26,244,786.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,577,500.00 | 4,309,021.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,748,400.00 | 12,688,870.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,246,900.00 | 9,246,895.00 |
| 210304 | Байрны түрээс | 1,500,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,154,600.00 | 3,224,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 407,900.00 | 407,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 313,800.00 | 313,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 251,000.00 | 201,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 688,300.00 | 688,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,993,600.00 | 1,113,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 76,099,500.00 | 51,816,520.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 424,300.00 | 424,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 73,918,200.00 | 49,635,220.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,757,000.00 | 1,757,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 710,600.00 | 638,070.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 470,600.00 | 398,070.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1880400.00 | 1880400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,380,400.00 | 1,380,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 188300.00 | 188300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 188,300.00 | 188,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 188,300.00 | 188,300.00 |
| **1310** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 558,917,800.00 | 551,675,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 530,845,000.00 | 523,602,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 530,845,000.00 | 523,602,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 28,072,800.00 | 28,072,800.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 28,072,800.00 | 28,072,800.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 37.00 | 37.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 25.00 | 25.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Данс-ны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **198000.00** | **140,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **198000.00** | **140,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 198000.00 | 140,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 198000.00 | 140,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 198000.00 | 140,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 198000.00 | 140000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 198000.00 | 140,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 198000.00 | 140,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Г.Алтансувд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 04–ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэг 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг өөрийгөө хөгжүүлэхэд дэмжсэн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд эцэг эх олон нийтийн хамтын ажиллагааг уялдуулж багш, ажилчдыг мэргэжлээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжоор нь хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт, дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 600,730.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 12,014.6 мянган

төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,770.8 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна. өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 831.6 | 831.6 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 77,151.4 | 68,059.1 | -9,092.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,391,248.9 | 1,425,280.6 | 34,031.5 |
| **Нийт хөрөнгө** | **1,468,400.4** | **1,494,171.3** | **25,770.8** |
| Өр төлбөр | 0 | 831.6 | 831.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,468,400.4 | 1,493,339.6 | 24,939.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,468,400.4** | **1,494,171.3** | **25,770.8** |

Авлага, өглөгийн дансны үлдэгдэл 831.6 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсан тул санхүүгийн тайлангаар авлага, өглөг үүсгүүлсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 68,059.1 мянган төгрөг болж 9,902.3 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалаас үндсэн хөрөнгийн данс руу хөрөнгө шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,425,280.6 мянган төгрөг болж 34,031.5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 60,159.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,493,339.6 мянган төгрөг болж 24,939.2 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 105,644.6 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 44,689.9 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 746,105.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 746,105.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 146,163.2 мянган төгрөгөөр бууруулж 599,942.2 мянган төгрөгөөр баталсан боловч Ковид –19 өвчний улмаас тодотгол хийгдэж 558,917.8 мянган төгрөг болсон байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 558,917.8 мянган төгрөгийн төсөв батласнаас улсын төсвөөс 530,845.0 мянган төгрөг, 28,072.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 558,917.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал үйл ажиллагаанд 530,401.7 мянган төгрөгийг зарцуулж 28,516.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 530,401.7 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого**

Улсын /орон нутгийн/ төсөвт орлого төвлөрүүлдэггүй байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд буюу цахим тендерээс бий болсон 140.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 140.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, төсвийн байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 8 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.7 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 61,915.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 61,915.4 | 1 | 61,915.4 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 1 | 61,915.4 | 1 | 61,915.4 | 0.0 | 0.0 | 100.0 |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,081.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 41,542.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,539.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 831,587.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцон нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулав.

2. Үнэ төлбөргүй орлогодсон 40,710,900 төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар бүртгэсэн байсныг залруулав.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 6,497.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүллээ.

Үүнд:

1. Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 8 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5707.8 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 831,587.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..."гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020

А

Аудитын нэр: ***Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/66/СТА-ТШ3

Шалгагдсан байгууллагын нэр: ***Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар цэцэрлэг***

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн 8 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.7 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна. | 5,707.8 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Г.Алтансувд Б.Ганчимэг |
| 2 | Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 789,385.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон байна. | 831.6 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Г.Алтансувд Б.Ганчимэг |
| 3 | Үнэ төлбөргүй орлогодсон 40,710,900 төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар бүртгэсэн байсныг залруулав. | 40,710.9 | Алдааг залруулсан | Эрхлэгч, Нягтлан бодогч | Г.Алтансувд Б.Ганчимэг |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 789,385.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцон нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулав. | 831.6 | Алдааг залруулсан | Эрхлэгч, Нягтлан бодогч | Г.Алтансувд Б.Ганчимэг |
| **ДҮН** | | 48,081.9 | | | |